




2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

ᠪᠣᠯᠣᠪᠰᠢᠷᠣᠯ,
ᠰᠢᠨᠵᠢᠯᠡᠬᠡ
ᠤᠬᠠᠭᠠᠨᠢ
ᠶ᠋ᠠᠮ

“МБТБС-ын байгууллагын засаглал удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх, багшийг чадваржуулах, түншлэлийг шинэ шатанд гаргах, сургалтын төрөл бүрийн хэлбэрийг хүлээн зөвшөөрч олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх замаар **“ЧАНАРТАЙ СУРГАЛТ – ЧАДАМЖТАЙ ТӨГСӨГЧ бэлтгэх**



1. Мэргэжлийн болон техникийн боловсролын эрх зүйн орчин

2. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын засаглал менежмент

3. Сургалтын агуулга, арга зүй, үнэлгээ

4. Багш, суралцагчийн хөгжил, нийгмийн баталгаа

ᠪᠣᠯᠣᠪᠰᠢᠷᠣᠯ,
ᠰᠢᠨᠵᠢᠯᠡᠬᠡ
ᠤᠬᠠᠭᠠᠨᠢ
ᠶ᠋ᠠᠮ

Мэргэжлийн болон техникийн боловсролын эрх зүйн орчин



1. Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийг оролцогч талуудад сурталчлан таниулах, хэрэгжүүлэхэд хамтран ажиллах
2. Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд нийцүүлэн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын дотоод харилцааг зохицуулсан дүрэм, журмыг шинэчлэх

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢ
ᠵᠢᠰᠭᠢ ᠬᠡ ᠭᠠᠷ
ᠪᠣᠯᠣᠪᠰᠢᠷᠣᠯ,
ᠰᠢᠨᠵᠢᠯᠡᠬᠡ ᠤᠬᠠᠠᠨᠢ
ᠶ᠋ᠠᠮ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢ
ᠵᠢᠰᠭᠢ ᠬᠡ ᠭᠠᠷ
ᠪᠣᠯᠣᠪᠰᠢᠷᠣᠯ,
ᠰᠢᠨᠵᠢᠯᠡᠬᠡ ᠤᠬᠠᠠᠨᠢ
ᠶ᠋ᠠᠮ

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын засаглал менежмент



1. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын судалгаа, арга зүй, үнэлгээний үйл ажиллагааны зохион байгуулалтын нэгдмэл байдлыг хангаж, сургалтын байгууллагуудыг төрөлжүүлэн салбар дундын дадлагын бааз, гарааны компани байгуулах ажлыг эхлүүлэх
2. Чанар, гүйцэтгэлийн үр дүнд суурилсан удирдлага, санхүүжилтийн шинэ тогтолцоог нэвтрүүлж, мэргэжлийн өөрийн өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, өөрийн болон туслах үйл ажиллагаанаас орлогыг нэмэгдүүлэх
3. Мэргэжлийн болон техникийн боловсролын түншлэлийг сургалт үйлдвэрлэлтэй холбох, хосмог болон ажлын байран дахь сургалт, дагалдан суралцах сургалтыг аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран чанартай зохион байгуулах
4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байгаль орчинд ээлтэй, хүртээмжтэй сургалтын орчин бүрдүүлж, дадлагын газрын техник тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг мэргэжлийн болон техникийн боловсролын орчны стандартад нийцүүлэх.

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠮᠤᠨᠵᠢᠯᠢᠭᠡᠨ
ᠮᠤᠨᠤᠯᠠᠭᠤᠨ
ᠵᠢᠰᠢᠭᠢᠨ ᠭᠠᠵᠠᠷ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠮᠤᠨᠵᠢᠯᠢᠭᠡᠨ
ᠮᠤᠨᠤᠯᠠᠭᠤᠨ
ᠵᠢᠰᠢᠭᠢᠨ ᠭᠠᠵᠠᠷ

Сургалтын агуулга, арга зүй, үнэлгээ



1. Ажил мэргэжлийн стандартад суурилсан, мэргэшлийн түвшинтэй уялдуулан хөтөлбөрийн агуулгыг шинэчлэх
2. Суралцагчийн ялгаатай хэрэгцээ, ур чадварын түвшнийг харгалзан сургалтын хөтөлбөрт тохируулга хийж, тэгш хамран сургах хэрэгцээг хангах
3. Сургалтын агуулга, арга зүйд нийцсэн сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний хүрэлцээ, хангамжийг нэмэгдүүлэх
4. Иргэн орон зай, цаг хугацаанаас үл хамааран мэргэжил, боловсрол, мэдлэг, ур чадвар, чадамжаа тасралтгүй хөгжүүлэх, мэргэшлийн түвшин ахиулахад чиглэсэн насан туршийн боловсрол, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх
5. Сургалтын байгууллагын дотоодын болон хөндлөнгийн үнэлгээн дэх суралцагчийн мэдлэг, ур чадвар, чадамжийн түвшнийг бодитой үнэлдэг болох
6. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр дээд боловсролын байгууллагад элсэн суралцахад хөтөлбөрийн агуулга, багц цагийг дүйцүүлэн тооцох.

Боловсрол, шинжлэх ухааны яам

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР
БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ

Багш, суралцагчийн хөгжил, нийгмийн баталгаа

1. Багшийг шинээр болон давтан бэлтгэх агуулга, арга хэлбэрийг тодорхойлж, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах
2. Багшийн өмнө тулгарч байгаа шинэ, нэмэлт ур чадварыг эзэмшүүлэх, инноваци, шинэ техник, технологи, стандарт, норматив, хөдөлмөр зохион байгуулалтын дэвшилтэт арга барил, ногоон хөгжлийг дэмжсэн чадавхыг бэхжүүлэх
3. Суралцагчид дараагийн түвшний сургалтын байгууллагад дэвших, үе тэнгийн бусад суралцагчидтай ижил хөтөлбөрөөр суралцаж, мэдлэг, ур чадвар эзэмших тэгш боломжийг бүрдүүлэх
4. Суралцагч бүр сургалтын байгууллагын орчинд амар тайван суралцах, аливаа хэлбэрийн бие болон сэтгэл зүйн гадуурхал, гэмт хэрэг, зөрчил, дарамт, дээрэлхэлтээс ангид, тэгш, хүртээмжтэй, эрүүл, аюулгүй суралцах нөхцөлийг бүрдүүлэх
5. Бүс нутгийн онцлог, бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөр, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн элсэлтийг зохион байгуулж, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх.



АНХААРАЛ ТАВЬСАН ТА БҮХЭНД БАЯРЛАЛАА

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ
ᠵᠠᠰᠭᠢᠨ ᠭᠠᠪᠠᠷ

ᠪᠣᠯᠣᠪᠰᠢᠷᠣᠯ,
ᠰᠢᠨᠵᠢᠯᠡᠬᠡ ᠤᠬᠠᠠᠨᠢ
ᠶ᠋ᠠᠮ